

**ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 2 ДУГААР
УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны 07-р сарын 31-ний өдөр

Хэнтий аймаг

1. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.6 дахь хэсэг, Шилэн дансны тухай хууль, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 03 тоот албан даалгавар, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын Захиргаа хяналтын хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэв.

2. ХЯНАЛТЫН ЗОРИЛГО

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2025 оны 2 дугаар улирлын байдлаарх шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулалт, холбогдох баримт бичгийг бүрэн оруулсан байдалд хяналт хийж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахад гол зорилго оршино.

3. ХЯНАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шалгалтад Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлсэн эсэхийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацааг хамрууллаа. Шалгалтыг Захиргаа хяналтын хэлтсийн дарга Н.Цолмонбаяр, хяналт шалгалтын улсын байцаагч Б.Цэнгэл нар 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хийж гүйцэтгэлээ.

**4. ХЯНАЛТЫН АРГА АРГАЧЛАЛ, ТАЙЛАНТ ОНД /УЛИРАЛД/ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН
АЖЛЫН ТАЛААР**

4.1. АРГА АРГАЧЛАЛ

Хяналт шинжилгээг гүйцэтгэхэд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг харилцах дансдын хуулга, мөнгөн хөрөнгө зарцуулах тухай А, Б тушаал, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, батлагдсан төсөв, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, холбогдох сарын мэдээ зэрэгт үндэслэн хяналт хийж, байршуулсан мэдээ, мэдээллийг баримтаар тулган шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах зэрэг арга зүйг ашиглан нотлох баримт цуглуулан хэрэгжүүлсэн.

4.2. ТАЙЛАНТ УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэл байршуулалттай холбоотой дараах ажлыг хийц гүйцэтгэсэн. Үүнд:

Шилэн дансны 2024 оны 4 дүгээр улирлын тайланг Дотоод аудит мониторингийн газарт хүргүүлэн ажилласан.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай 03 дугаар албан даалгаврын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит мониторингийн газраас Шилэн дансны мэдээлэл байршуулалтад 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар хяналт шалгалт хийсэн. Шалгалтын бэлтгэл ажлыг ханган, холбогдох баримт материалыг хүргүүлсэн.

5. ХЯНАЛТЫН ҮР ДҮН

Хяналт шинжилгээгээр байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т байршуулсан байдлыг холбогдох баримттай тулган шалгалаа.

Шалгалтаар 2025 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг дараах байдлаар байршуулсан байна.

Мэдээлэл байршуулалт	Нийт	Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа	Нийгмийн даатгалын сан
Нийт мэдээлэл	184	95	89
Хугацандаа оруулсан мэдээлэл	183	94	89
Хугацаа хоцорсон мэдээлэл	1	1	0
Оруулаагүй мэдээлэл	0	0	0
Нийт мэдээлэл байршуулсан хувь	100%	100%	100%
Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь	99%	98%	100%

5.1 Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төсөв, гүйцэтгэлийн тайлан, мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн гүйцэд оруулсан тухай;

ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

1. Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн сар бүрийн мэдээг 1-6 дугаар саруудад хугацаанд нь байршуулсан
2. Үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийн зориулалт, зарцуулалтын мэдээг сар бүр хуулийн хугацаанд 6 удаа байршуулсан
3. Үйл ажиллагааны хагас жилийн санхүүгийн тайлан мэлээлэх хуулийн хугацаа болоогүй.
 4. Хандив тусламжийн орлого байхгүй тул хуулийн хугацаанд хаасан
 5. Хандив тусламжийн зарцуулалтын тайлан байхгүй тул хуулийн хугацаанд хаасан
 6. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан байхгүй тул хуулийн хугацаанд хаасан
 7. 2025 оны үйл ажиллагааны жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээлэх хуулийн хугацаа болоогүй

8. 2025 оны үйл ажиллагааны батлагдсан төсвийг 01 дүгээр сарын 10-ны өдөр хуулийн хугацаанд байршуулсан

9. Дараа жилийн төсвийн төслийн төлөвлөгөө мэдээлэх хуулийн хугацаа болоогүй

10. Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан байхгүй

11. Хандив, тусламжийн орлого байхгүй

12. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан байхгүй

13. 2025 оны үйл ажиллагааны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлэх хуулийн хугацаа болоогүй

Тухай бүр мэдээлэх:

14. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг хуулийн хугацаанд 6 удаа мэдээдсэн бөгөөд 2, 5 сард гүйлгээ гарсан, бусад саруудад гүйлгээ гараагүй байна

15. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг хуулийн хугацаанд 6 удаа байршуулсан.

16. 2025 оны жилийн төсөвт 3, 5, 6 саруудад нэмэлт, өөрчлөлт орсныг мэдээлсэн байна

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ

1. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гараагүй тул сар бүр хугацаанд нь хаасан

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гараагүй тул хуулийн хугацаанд хаасан

3. Худалдан авах ажиллагааны тайланг төлөвлөгөө гараагүй тул хуулийн хугацаанд хаасан

4. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт оны эхэнд боловсруулаагүй тул хуулийн хугацаанд хаасан

5. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл байхгүй тул тухай бүр хаасан

6. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээг 6 удаа хуулийн хугацаанд байршуулсан байна.

БУСАД

1. Нийгмийн даатгалын газрын батлагдсан орон тооны мэдээллийн **2 дугаар сарыг хугацаа хоцроон байршуулсан**. Бусад сарыг мэдээллийг сар бүр хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Жил бүр мэдээлэх:

2. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн мэдээлэх хугацаа болоогүй

Тухай бүр мэдээлэх:

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл гараагүй тул сар бүр хуулийн хугацаанд хаасан

4. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 1, 2, 5 сард гарсныг хавсралт баримтын хамт хуулийн хугацаанд байршуулсан. Бусад саруудыг хуулийн хугацаанд хаасан болно

5. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт байхгүй тул хаасан

6. Худалдах, худалдан авах ажиллагаа хийгдээгүй. Үүнтэй холбоотой аудит, хөндлөнгийн хяналт шалгалт ороогүй тул хуулийн хугацаанд тухай бүр шилэн дансны цахим хуудасны мэдээлэл байршуулах хэсгийг хаасан байна.

2025 оны эхний хагас жилийн төсвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, мэдээ 95 байршуулах байснаас 94 мэдээг хуулийн хугацаанд байршуулсан байна. Үүнээс бусад цэсны 1 дэх хэсэгт байршуулах Нийгмийн даатгалын газрын батлагдсан орон тооны мэдээллийн 2 дугаар сарыг хугацаа хоцроон байршуулсан зөрчил гарсан.

5.2 Нийгмийн даатгалын газрын 2025 оны сангийн төсөв, гүйцэтгэлийн тайлан, мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг бүрэн гүйцэд оруулсан тухай;
ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

1. Сангийн төсвийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 2025 оны 1-6 дугаар сарыг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан

2. Сангийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр, зориулалтыг 1-6 дугаар саруудад хугацаанд нь мэдээлсэн

3. Хандив тусламжийн орлого байхгүй тул хуулийн хугацаанд хаасан

4. Хандив тусламжийн зарцуулалтын тайлан байхгүй тул хуулийн хугацаанд хаасан

5. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан байхгүй тул хуулийн хугацаанд хаасан

6. Сангийн тайлангын гүйцэтгэлийг мэдээлэх хугацаа болоогүй

7. 2025 оны үйл ажиллагааны батлагдсан төсвийг 01 дүгээр сарын 10-ны өдөр хуулийн хугацаанд байршуулсан

8. Дараа жилийн төсвийн төслийн төлөвлөгөө мэдээлэх хуулийн хугацаа болоогүй

9. Жилийн эцсийн санхүүгийн тайланг мэдээлэх хугацаа болоогүй

10. Сангийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх хугацаа болоогүй

11. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 1-6 саруудад хугацаанд нь байршуулсан

12. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 1-6 саруудад хуулийн хугацаанд байршуулсан

13. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт 2, 3, 5, 6 саруудад тухай бүр байршуулсан.

14. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл байхгүй тул хуулийн хугацаанд хаасан

15. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан байхгүй тул хуулийн хугацаанд хаасан

16. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл байхгүй тул хуулийн хугацаанд хаасан

БУСАД

1. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээлэх хугацаа болоогүй

2. Сангийн төсвийн сар, улирлын хуваарийн хавсралтыг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан

3. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл хамаарахгүй тул хуулийн хугацаанд хаасан

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл хамаарахгүй тул хуулийн хугацаанд хаасан
5. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт байхгүй тул хуулийн хугацаанд хаасан
6. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй тул хуулийн хугацаанд хаасан
7. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн байхгүй тул хуулийн хугацаанд хаасан

Тус газар нь 2025 оны хагас жилийн байдлаар сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, мэдээ 89 байршуулах байснаас 89 мэдээллийг байршуулсан байна. Мөн шилэн дансны цахим хуудсанд байршуулах сангийн мэдээнээс Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хамаарахгүй мэдээллийг шилэн дансны хууль, холбогдох журамд заасны дагуу хуулийн хугацаанд хааж мэдээллийг байршуулсан байна.

6. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газрын 2025 оны хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын сангийн нийт 89 мэдээлэл байршуулахаас 89 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт нийт 95 мэдээлэл байршуулахаас 94 мэдээллийг хугацаанд нь байршуулсан боловч Нийгмийн даатгалын газрын батлагдсан орон тооны мэдээллийн 2 дугаар сарыг хугацаа хоцроон байршуулсан 1 зөрчил гарсан. Зөрчил гарснаас хойш мэдээллийг 31 хоногийн дараа шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

7. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Шалгалтын явцад шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулах, мэдээлэх үүрэгтэй үйл ажиллагааны нягтлан бодогч, сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнгүүдэд Шилэн дансны тухай хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийг баримтлан шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажилласан.

ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

— оОо —